



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СЭА-2026/017-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Утас:7036-3040	Б.Батмөнх
Сүхбаатар сум 2026 он	Ахлах аудитор: Утас: 7036-3036	Цахим хаяг: <a href="mailto:Batmunkhb@audit.gov.mn">Batmunkhb@audit.gov.mn</a>
	Аудитор: Утас: 7036-3047	Ц.Отгонбаяр
		Цахим хаяг: <a href="mailto:Otgonbayarts@audit.gov.mn">Otgonbayarts@audit.gov.mn</a>
		Ж.Цогт
		Цахим хаяг: <a href="mailto:Tsogtj@audit.gov.mn">Tsogtj@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА Э.ОЮУНБОЛД ТАНАА

2026.02.25 № СЭА-2026/017-НА-СТА-РМБ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- БНХАУ-ын Гуанжоу хотод зохион байгуулагдсан "Canton fair 2025" үзэсгэлэнд оролцож туршлага судлах зорилгоор аялал жуулчлал, зочид буудлын үйл ажиллагаа эрхэлдэг "Болор тулга эрдэм" ХХК-тай сургалтын гэрээ байгуулан аймгийн ИТХ-ын 38 төлөөлөгч нийт **166,820.0** мянган төгрөгийг зарцуулсан,
- Өртгөө бүрэн нөхөөгүй, элэгдэх жил бүрэн дуусаагүй **63,000.0** мянган төгрөгийн хөрөнгийг акталж, бусдад шилжүүлсэн,
- Өмнөх аудитаар өгсөн хариуцлага тооцуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3, 4.2.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.1.2-д заасныг болон Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд аймгийн ЗДНХ-өөс 169,680.0 мянган төгрөгийн 41 ширхэг Ipad, аймгийн ЗДТГ-аас 245,000.0 мянган төгрөгийн Toyota Land Cruiser 300 маркийн авто машин зэрэг нийт 414,680.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аймгийн ИТХ-ын төсөвт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хөтөлбөрийн зардлаас аймаг болон Мандал, Сайхан сумд дахь Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 413 дугаар анги, Хилийн цэргийн 0101 дүгээр анги, Прокурорын газар зэрэг хууль, хяналтын байгууллагууд болон аймгийн Боловсролын газар, ерөнхий боловсролын 35 сургуульд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд 252,661.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г 7 зорилт, 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 96.0 хувийн биелэлттэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	23,314,235.0	27,389,235.0
35	БАРАА МАТЕРИАЛ	23,314,235.0	27,389,235.0
35400	Хангамжийн материал	23,314,235.0	27,389,235.0
35410	Бичиг хэргийн материал	6,602,000.0	9,166,250.0
35420	Аж ахуйн материал	14,675,130.0	15,220,130.0
35440	Түлш, шатах тослох материал	2,005,105.0	100,105.0
35470	Бусад хангамжийн материал	32,000.0	2,902,750.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	85,522,247.8	462,925,355.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	85,522,247.8	462,925,355.7
39200	Биет хөрөнгө	85,522,247.8	462,925,355.7
39203	Авто-тээврийн хэрэгсэл	126,800,000.0	260,000,000.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(126,800,000.0)	(21,125,000.0)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	128,959,700.0	232,639,800.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	(76,179,479.5)	(34,941,559.3)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,459,200.0	42,619,500.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,717,172.7)	(16,267,385.0)
39301	Программ хангамж	880,000.0	-
39302	Хуримтлагдсан элэгдэл	(880,000.0)	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	108,836,482.8	490,314,590.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	14,207,750.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	14,207,750.0
41300	Өглөг	-	14,207,750.0
41360	Бусад өглөг	-	14,207,750.0
41361	Байгууллагад төлөх өглөг	-	14,207,750.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	108,836,482.8	476,106,840.7
51	Засгийн газрын хувь оролцоо	108,836,482.8	476,106,840.7
51100	Засгийн газрын оруулсан капитал	99,213,204.0	-
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	99,213,204.0	-
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	-	99,213,204.0
51200	Хуримтлагдсан үр дүн	9,623,278.8	376,893,636.7
51210	Өмнөх үеийн үр дүн	(2,550,176.0)	9,623,278.8
51220	Тайлант үеийн үр дүн	12,173,454.8	367,270,357.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	108,836,482.8	490,314,590.7

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,673,258,162.6	2,115,767,500.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	230,422.0	2,115,767,500.0
120	Нийтлэг татварын бус орлого	230,422.0	414,680,000.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	230,422.0	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	230,422.0	-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	414,680,000.0
122	Тусламжийн орлого	-	1,701,087,500.0
1221	Хандив тусламж /дотоод/	-	1,701,087,500.0
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	1,701,087,500.0

122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	1,701,087,500.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,673,027,740.6	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	121,000,000.0	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	121,000,000.0	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,552,027,740.6	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,552,027,740.6	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,661,084,707.8	1,744,265,747.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,661,084,707.8	1,744,265,747.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,275,722,068.8	1,452,097,557.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	380,899,666.0	509,645,443.2
210101	Үндсэн цалин	192,193,843.6	253,222,335.9
210102	Нэмэгдэл	146,554,665.3	210,434,544.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,750,000.0	36,920,363.0
210104	Урамшуулал	22,401,157.2	9,068,200.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,843,323.8	64,732,046.4
210201	Тэтгэврийн даатгалын зардал	32,260,205.4	44,845,503.1
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	3,888,798.1	5,135,666.2
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	1,925,919.1	2,567,833.1
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	1,755,264.3	2,361,536.7
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	7,013,137.0	9,821,507.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,201,200.0	-
210301	Гэрэл, цахилгаан	5,715,000.0	-
210302	Түлш, халаалт	27,371,500.0	-
210303	Цэвэр, бохир ус	5,114,700.0	-
2104	Хангамж, бараа материалын зардал	100,713,989.0	63,282,064.9
210401	Бичиг хэрэг	49,676,346.0	19,619,545.0
210402	Тээвэр, шатахуун	17,770,172.0	24,660,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,602,436.0	1,895,644.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	31,665,035.0	17,050,875.0
210408	Бараа материал актисны зардал	-	56,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,000,000.0	15,000,000.0
210604	Урсгал засвар	20,000,000.0	15,000,000.0
2107	Томилот, зочны зардал	17,541,000.0	17,050,800.0
210702	Дотоод албан томилот	17,541,000.0	17,050,800.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	600,350,320.8	526,496,956.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	597,773,656.8	525,079,987.2
210803	Даатгалын үйлчилгээ	1,260,525.0	115,830.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	206,139.0	206,139.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.0	22,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,088,000.0	1,073,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71,172,569.2	255,890,247.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	737,400.0	111,500.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	40,884,340.0	222,733,250.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,550,829.2	33,045,497.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	385,362,639.0	292,168,189.3

2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	180,000,000.0	205,000,000.0
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	180,000,000.0	205,000,000.0
213101	Бусад засгийн газрын дотоод шилжүүлэг	180,000,000.0	205,000,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	205,362,639.0	4,652,000.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	142,213,360.0	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	42,435,259.0	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,714,020.0	4,652,000.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	82,516,189.3
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	82,516,189.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	12,173,454.8	371,501,753.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	4,231,395.1
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	4,231,395.1
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-	(4,231,395.1)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	12,173,454.8	367,270,357.9

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,673,027,740.6	1,701,087,500.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,701,087,500.0
122	Тусламжийн орлого	-	1,701,087,500.0
1221	Хандив тусламж /дотоод/	-	1,701,087,500.0
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	1,701,087,500.0
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	1,701,087,500.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,673,027,740.6	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	121,000,000.0	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	121,000,000.0	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,552,027,740.6	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,552,027,740.6	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,637,326,740.6	1,701,087,500.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,637,326,740.6	1,701,087,500.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,251,964,101.6	1,408,919,310.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	380,899,666.0	509,645,443.2
210101	Үндсэн цалин	192,193,843.6	253,222,335.9
210102	Нэмэгдэл	146,554,665.3	210,434,544.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,750,000.0	36,920,363.0
210104	Урамшуулал	22,401,157.2	9,068,200.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,843,323.8	64,732,046.4
210201	Тэтгэврийн даатгалын зардал	32,260,205.4	44,845,503.1
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	3,888,798.1	5,135,666.2
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	1,925,919.1	2,567,833.1
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	1,755,264.3	2,361,536.7
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	7,013,137.0	9,821,507.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,201,200.0	-
210301	Гэрэл, цахилгаан	5,715,000.0	-
210302	Түлш, халаалт	27,371,500.0	-

210303	Цэвэр, бохир ус	5,114,700.0	-
2104	Хангамж, бараа материалын зардал	57,001,473.8	43,956,864.9
210401	Бичиг хэрэг	18,694,050.0	5,948,795.0
210402	Тээвэр, шатахуун	11,000,000.0	17,225,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,602,436.0	1,895,644.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	25,704,987.8	18,887,425.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,844,930.0	15,000,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,365,030.0	-
210602	Тавилга	479,900.0	-
210604	Урсгал засвар	20,000,000.0	15,000,000.0
2107	Томилолт, зочны зардал	17,541,000.0	17,450,800.0
210702	Дотоод албан томилолт	17,541,000.0	17,450,800.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	636,297,020.8	553,170,406.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	633,720,356.8	551,753,437.2
210803	Даатгалын үйлчилгээ	1,260,525.0	115,830.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	206,139.0	206,139.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.0	22,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,088,000.0	1,073,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,335,487.3	204,963,750.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	966,147.3	3,111,500.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	45,369,340.0	201,852,250.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	385,362,639.0	292,168,189.3
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	180,000,000.0	205,000,000.0
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	180,000,000.0	205,000,000.0
213101	Бусад засгийн газрын дотоод шилжүүлэг	180,000,000.0	205,000,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	205,362,639.0	4,652,000.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	142,213,360.0	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	42,435,259.0	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,714,020.0	4,652,000.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	82,516,189.3
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	82,516,189.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	35,701,000.0	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	35,701,000.0	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	35,701,000.0	-
2200	Дотоод эх үүсвэрээр	35,701,000.0	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	35,701,000.0	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(35,701,000.0)	-

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	99,213,204.0	-	(2,550,176.0)	96,663,028.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	99,213,204.0	-	(2,550,176.0)	96,663,028.0
9	Тайлант үеийн үр дүн	-	-	12,173,454.8	12,173,454.8
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	99,213,204.0	-	9,623,278.8	108,836,482.8
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	99,213,204.0	-	9,623,278.8	108,836,482.8

13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	99,213,204.0	-	9,623,278.8	108,836,482.8
19	Тайлант үеийн үр дүн	-	-	367,270,357.9	367,270,357.9
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	99,213,204.0	-	376,893,636.7	476,106,840.7

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,854,733,100.0	1,701,087,500.0	153,645,600.0	91.7
12	Татварын бус орлого	1,854,733,100.0	1,701,087,500.0	153,645,600.0	91.7
122	Тусламжийн орлого	1,854,733,100.0	1,701,087,500.0	153,645,600.0	91.7
122005	Төсвөөс санхүүжих	1,854,733,100.0	1,701,087,500.0	153,645,600.0	91.7
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,854,733,100.0	1,618,571,310.7	236,161,789.3	87.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,854,733,100.0	1,618,571,310.7	236,161,789.3	87.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,635,733,100.0	1,408,919,310.7	226,813,789.3	86.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	527,605,800.0	509,645,443.2	17,960,356.8	96.6
210101	Үндсэн цалин	234,154,200.0	253,222,335.9	(19,068,135.9)	108.1
210102	Нэмэгдэл	233,563,300.0	210,434,544.3	23,128,755.7	90.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	50,820,000.0	36,920,363.0	13,899,637.0	72.6
210104	Урамшуулал	9,068,300.0	9,068,200.0	100.0	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,950,000.0	64,732,046.4	1,217,953.6	98.2
210201	Тэтгэврийн даатгал	44,846,500.0	44,845,503.1	996.9	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	5,276,100.0	5,135,666.2	140,433.8	97.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,638,000.0	2,567,833.1	70,166.9	97.3
210204	Ажилгүйдлийн даатгал	2,638,000.0	2,361,536.7	276,463.3	89.5
210205	Эрүүл мэндийн даатгал	10,551,400.0	9,821,507.2	729,892.8	93.1
2104	Хангамж, бараа материалын зардал	76,633,200.0	43,956,864.9	32,676,335.1	57.4
210401	Бичиг хэрэг	9,580,700.0	5,948,795.0	3,631,905.0	62.1
210402	Тээвэр, шатахуун	21,212,500.0	17,225,000.0	3,987,500.0	81.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,200,000.0	1,895,644.9	5,304,355.1	26.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	38,640,000.0	18,887,425.0	19,752,575.0	48.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,810,000.0	15,000,000.0	9,810,000.0	60.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,810,000.0	-	9,810,000.0	-
210604	Урсгал засвар	15,000,000.0	15,000,000.0	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	20,070,000.0	17,450,800.0	2,619,200.0	86.9
210702	Дотоод албан томилолт	20,070,000.0	17,450,800.0	2,619,200.0	86.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	656,202,100.0	553,170,406.2	103,031,693.8	84.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	644,820,000.0	551,753,437.2	93,066,562.8	85.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	389,500.0	-	389,500.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	2,205,000.0	115,830.0	2,089,170.0	5.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	288,000.0	206,139.0	81,861.0	71.6
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	39,600.0	22,000.0	17,600.0	55.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,460,000.0	1,073,000.0	7,387,000.0	12.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	264,462,000.0	204,963,750.0	59,498,250.0	77.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,910,000.0	3,111,500.0	798,500.0	79.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	260,552,000.0	201,852,250.0	58,699,750.0	77.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	219,000,000.0	209,652,000.0	9,348,000.0	95.7
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	205,000,000.0	205,000,000.0	-	100.0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	205,000,000.0	205,000,000.0	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,000,000.0	4,652,000.0	9,348,000.0	33.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,000,000.0	4,652,000.0	9,348,000.0	33.2

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт **234,729.7** мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 229,820.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 1 албан хаагчид хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэн, 4,909.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

Аудитаар нийт илрүүлсэн 234,729.7 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 16,610.8 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага:

**5.1.1** БНХАУ-ын Гуанжоу хотод зохион байгуулагдсан “Canton fair 2025” үзэсгэлэнд оролцож, туршлага судлахаар мэргэшсэн сургалтын байгууллагаар бус аялал жуулчлал, зочид буудлын үйл ажиллагаа эрхэлдэг “Болор тулга эрдэм” ХХК-тай сургалтын гэрээ байгуулан аймгийн ИТХ-ын 38 төлөөлөгч нийт **166,820.0** мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар зарцуулах”*, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь *“батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3 дахь *“хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх”*, 4.2.7 дахь *“аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх”*, Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолоор батлагдсан *“Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам”*-ын 3.5 дахь *“Төлөөлөгчдийг чадавхжуулах арга хэмжээг Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага болон холбогдох сургалтын чиглэлээр мэргэшсэн сургалтын бусад байгууллага, судлаачдын багтай хамтран зохион байгуулна”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулж, холбогдох хууль, журмыг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэв.

**5.1.2** Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд 2022 оны 01 дүгээр сараас ашиглалтын жилийг 4 жилээр бүртгэгдсэн, **63,000.0** мянган төгрөгийн дансны үнэ бүхий 36 ширхэг Ipad-ийг өртгөө бүрэн нөхөөгүй байхад аймгийн ИТХ-ын 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 50 дугаар тогтоолоор актлах шийдвэр гаргаж, хөрөнгийн бүртгэлээс хасан өмнөх ИТХ-ын төлөөлөгч нарт өгсөн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх *“... үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор*

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно”, УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 13 (б)-д “... байгууллага нь тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр түүний одоогийн бодит үнэ цэнийг үнэлж, данс бүртгэлээс хасах хэрэгтэй...” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ашиглах хугацаа нь дуусаагүй байхад хөрөнгийг акталж устгасан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Бүртгэл тайлагналтай холбоотой асуудал**

**1.1 Илрүүлэлт:** Тайлант онд худалдан авсан **4,909.7** мянган төгрөгийн бичиг хэргийн материал, цай кофег бөөн дүнгээр орлогод авч, үлдэгдлээр тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “... удирдлага, нягтлан бодогч нь ... үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Сангийн сайдын 2023 оны А/229 дүгээр тушаалын “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 8.21 дэх “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн байнгын системийг ашиглан бараа материалыг бүртгэнэ”, 8.21.(д) Бараа материалыг ажил, үйлчилгээнд зарцуулах үед: “Бараа материалыг ажил үйлчилгээнд ашиглахаар тавьж олгоход: Дт. Зардал /нэр төрлөөр/, Кт. Бараа материал /нэр төрлөөр/” гэсэн заалтууд болон УСНББОУС-ын 12: Бараа материал 12.16 дахь “Бараа материалыг арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн тохиолдолд тэдгээрийн өртгийг тухайн олж эзэмшсэн өдрөөрх бодит үнэ цэнээр хэмжинэ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:** Анхан шатны баримтыг үндэслэн бараа материалын хөдлөл, өөрчлөлтийг тухай бүр бүртгэж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>2</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төлөөлөгчдийг чадавхжуулах журмыг зөрчсөн.	1	166,820.0			1	166,820.0						
Элэгдэлээ бүрэн нөхөөгүй хөрөнгийг акталж, бусдад шилжүүлсэн.	1	63,000.0			1	63,000.0						
Бараа материалыг бөөн дүнгээр орлогод авч, үлдэгдлээр тайлагнасан.	1	4,909.7					1	4,909.7				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>234,729.7</b>			<b>2</b>	<b>229,820.0</b>	<b>1</b>	<b>4,909.7</b>	<b>1</b>	<b>1</b>		